

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/61/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
[www.audit.mn](#)
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 51-261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхбаатар
Утас: 51-260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Батцэцэг
Утас: 51-261628 Цахим хаяг: Battsetsegp@audit.gov.mn
Аудитор: С.Алтанхуяг
Утас: 51-261628 Цахим хаяг: altankhuyag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	17
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	17
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	18
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	19
3.5.1 Төсвийн төлөвлөлт	19
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	20
3.5.3 Нэмэлт төсөв.....	21
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	21
4. АУДИТЫН ТАЙЛАН	23
4.1 Ерөнхий зүйл	23
4.2 Материаллаг байдал.....	23
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	24
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	25
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	26
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	27
5.1 Төлбөрийн акт	27
5.2 Албан шаардлага	28
5.3 Зөвлөмж.....	30
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	34

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХС	Гадаад харилцааны сайд
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДБҮЭГ	Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/325
танай _____-ны № _____-т

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.МӨНХТҮШИГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн Гадаад харилцааны яамны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 1,308,730.0 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, 442,381.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 884,925.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авсан, мөн нэг төрлийн бараа, ажил үйлчилгээг гэрээ шууд байгуулах аргыг ашиглан олон хувааж худалдан авахаар төлөвлөсөн;
- Улсын тэмдэгтийн хураамжийн 1,308,730.0 мянган төгрөгийн орлогыг Төрийн банкны дансанд тухай бүр төвлөрүүлж /тэг үлдэгдэлтэй арилжааны банкны данс/, Сүхбаатар дүүргийн төрийн сангийн Улсын тэмдэгтийн хураамжийн татагддаг боловч, урсгал зардлын дансанд бөөн дүнгээр орлогоор бүртгэсэн;
- Хөрөнгийн тооллогыг хагас жилээр болон эд хөрөнгө хариуцагч, эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хийж хэвшээгүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг батлагдсан маягтын дагуу хөтөлж баталгаажуулаагүй зэрэг байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-т "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны 08 дугаар сард Зүүн Ази, Латин Америкийн хамтын ажиллагааны гишүүн орнууд (ФЕАЛАК)-ын Гадаад хэргийн сайд нарын 10 дугаар уулзалт, Олон улсын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулахад 1,523,543.4 мянган төгрөгийг төсөвлөж, гүйцэтгэлээр 1,522,830.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Төсвийн тодотголоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцаас Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах арга хэмжээний зардалд олон улсын 3 байгууллагатай байгуулсан гэрээний төлбөр 9,610,832.1 мянган төгрөгийг Гадаад харилцааны яамны төсөвт нэмж тодотгосон байна. Эдгээр нь өндөр үнийн дүнтэй, цуцлах тохиолдолд алданги, хүү тооцох хатуу нөхцөлтэй эрсдэл бүхий гэрээнүүд байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Засгийн Газрын 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолоор Гадаад харилцааны яамны, бүтцийг шинэчлэн баталсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,514,309,057.77	816,376,139.75
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	202,150,601.28	4,295,556.71
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	202,150,601.28	4,295,556.71
31210	Төгрөг	202,150,601.28	4,295,556.71
31211	Төрийн сангийн харилцах	201,286,963.00	4,237,191.00
31213	Арилжааны банк дахь харилцах	863,638.28	58,365.71
33	АВЛАГА	96,265,452.00	52,474,468.77
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,201,556.77
33300	Татаас, санхүүжилтийн авлага	90,515,624.00	19,723,084.00
33500	Бусад авлага	5,749,828.00	31,549,828.00
33510	Байгууллагаас авах авлага	-	25,800,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	5,749,828.00	5,749,828.00
34	УРЬДЧИЛГАА	744,688,142.98	1,742,720.83
34600	Урьдчилж гарсан зардал	744,688,142.98	1,742,720.83
35	БАРАА МАТЕРИАЛ	471,204,861.51	757,863,393.44
35100	Түүхий эд материал	121,608,000.00	256,368,000.00
35110	Тусгай зориулалттай материал	121,608,000.00	256,368,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	15,817,845.36	14,896,626.41
35400	Хангамжийн материал	333,779,016.15	486,598,767.03
35410	Бичиг хэргийн материал	1,512,706.80	-
35470	Бусад хангамжийн материал	332,266,309.35	486,598,767.03
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,890,949,524.44	15,470,268,679.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,890,949,524.44	15,470,268,679.41
39200	Биет хөрөнгө	13,839,950,678.53	14,450,374,263.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,520,430,367.55	14,140,515,615.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,406,240,874.85)	(2,053,057,694.79)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	875,800,000.00	875,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(61,412,109.59)	(236,572,109.57)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	5,329,682,407.27	4,977,628,437.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,969,281,518.46)	(3,770,280,951.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,748,754,582.46	1,400,085,875.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,292,180,384.85)	(978,143,118.48)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	86,193,135.00	86,193,135.00
39217	Ном	8,205,074.00	8,205,074.00
39300	Биет бус хөрөнгө	1,050,998,845.91	1,019,894,415.67
39301	Програм хангамж	575,785,512.00	404,809,078.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(500,534,666.09)	(360,662,662.33)
39303	Бусад биет бус хөрөнгө	975,748,000.00	975,748,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	16,405,258,582.21	16,286,644,819.16
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	197,049,772.00	264,904,143.08
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	197,049,772.00	264,904,143.08
41300	Өглөг	197,049,772.00	264,904,143.08
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	151,966,458.44
41360	Бусад өглөг	197,049,772.00	112,937,684.64
41361	Байгууллагад төлөх өглөг	197,049,772.00	112,937,684.64
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,208,208,810.21	16,021,740,676.08
51	Засгийн газрын хувь оролцоо	16,208,208,810.21	16,021,740,676.08
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,330,370,602.25	3,330,370,602.25
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	3,330,370,602.25	3,330,370,602.25
51200	Хуримтлагдсан үр дүн	11,982,749,423.33	11,796,281,289.20
51210	Өмнөх үеийн үр дүн	5,665,351,527.75	11,982,749,423.33
51220	Тайлант үеийн үр дүн	6,317,397,895.58	(186,468,134.13)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	895,088,784.63	895,088,784.63

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	16,405,258,582.21	16,286,644,819.16
---	--	--------------------------	--------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	40,534,524,418.23	37,742,576,584.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,999,350,803.74	37,742,576,584.54
120	Нийтлэг татварын бус орлого	1,999,350,803.74	2,427,980,336.54
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,999,350,803.74	1,590,341,144.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,622,487,690.74	1,590,341,144.04
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	376,863,113.00	-
120009	Бусад орлого	-	837,639,192.50
122	Тусламжийн орлого	-	35,314,596,248.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	35,314,596,248.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	34,124,653,898.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	34,124,653,898.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,189,942,350.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	882,990,850.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	306,951,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	38,535,173,614.49	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	33,589,232,063.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	28,772,436,621.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	4,816,795,442.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,945,941,551.49	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,040,046,551.49	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,905,895,000.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	34,217,126,522.65	37,929,044,718.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,217,126,522.65	37,929,044,718.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,330,799,462.16	32,838,495,704.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,199,172,294.71	7,457,822,574.40
210101	Үндсэн цалин	6,199,172,294.71	6,285,935,355.54
210102	Нэмэгдэл	-	480,560,383.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	691,326,835.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	764,289,920.11	928,133,633.58
210201	Тэтгэврийн даатгалын зардал	764,289,920.11	640,982,131.71
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	-	71,888,857.97
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	-	35,878,669.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	-	35,872,875.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	-	143,511,099.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,590,099.23	236,784,219.97
210301	Гэрэл, цахилгаан	78,032,841.97	130,361,820.24
210302	Түлш, халаалт	82,611,620.72	78,709,521.51
210303	Цэвэр, бохир ус	24,945,636.54	27,712,878.22
2104	Хангамж, бараа материалын зардал	303,309,292.47	279,288,347.10
210401	Бичиг хэрэг	93,902,920.90	78,499,491.80
210402	Тээвэр, шатахуун	73,027,095.50	14,321,175.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	89,230,817.02	131,293,192.30

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	5,925,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,148,459.05	48,841,508.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	407,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,947,386.52	90,879,062.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,727,499.00	33,130,393.00
210604	Урсгал засвар	47,219,887.52	57,748,669.60
2107	Томилолт, зочны зардал	10,370,233,276.92	17,093,395,841.11
210701	Гадаад албан томилолт	4,116,897,534.32	3,735,152,329.74
210702	Дотоод албан томилолт	31,019,986.00	12,640,405.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,222,315,756.60	13,345,603,106.37
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,058,257,470.13	2,603,787,486.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,429,490,210.62	2,049,314,307.38
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	550,102,120.51	500,719,979.16
210807	Газрын төлбөр	78,585,139.00	53,753,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	80,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,391,999,722.07	4,148,404,539.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,445,423,189.00	2,797,522,247.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	595,000.00	15,155,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	945,981,533.07	1,335,727,292.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,886,327,060.49	5,090,549,013.71
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,261,199,862.38	3,298,720,923.10
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,261,199,862.38	3,298,720,923.10
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	603,425,583.93
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	464,184,785.10
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	139,240,798.83
213101	Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг	2,261,199,862.38	2,695,295,339.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	908,819,360.95	483,098,081.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	110,620,000.00	2,640,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	456,298,081.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	798,199,360.95	24,160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,490,080,605.62	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,388,983,265.62	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	101,097,340.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,226,227,231.54	1,308,730,009.61
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,226,227,231.54	1,308,730,009.61
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,317,397,895.58	(186,468,134.13)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	6,317,397,895.58	(186,468,134.13)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	40,902,196,759.74	36,858,470,992.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,594,926,862.74	36,858,470,992.33
120	Нийтлэг татварын бус орлого	1,594,926,862.74	1,456,341,144.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,397,877,090.74	1,456,341,144.04
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	172,630,350.94	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,225,246,739.80	1,456,341,144.04
120009	Бусад орлого	197,049,772.00	-
122	Тусламжийн орлого	-	35,402,129,848.29
1221	Хандив тусламж /дотоод/	-	35,402,129,848.29
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	34,121,644,374.29
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	34,121,644,374.29
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,280,485,474.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	90,515,624.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	882,990,850.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	306,979,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,307,269,897.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	33,589,232,063.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	28,772,436,621.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	4,816,795,442.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,718,037,834.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	109,557,494.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,477,925,900.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,130,554,440.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,616,744,078.88	36,434,405,460.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,616,744,078.88	36,434,405,460.31

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,206,727,045.88	31,327,142,886.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,184,912,778.12	7,208,692,933.46
210101	Үндсэн цалин	3,389,786,026.51	3,844,942,268.10
210102	Нэмэгдэл	1,825,283,905.73	2,161,676,880.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	422,130,272.55	772,228,326.38
210104	Урамшуулал	547,712,573.33	429,845,458.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	778,549,436.70	897,545,194.43
210201	Тэтгэврийн даатгалын зардал	533,252,265.23	610,393,692.56
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	62,710,595.88	71,888,857.97
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	30,929,598.05	35,878,669.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	30,331,395.56	35,872,875.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	121,325,581.98	143,511,099.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,590,099.23	259,784,219.97
210301	Гэрэл, цахилгаан	78,032,841.97	153,361,820.24
210302	Түлш, халаалт	82,611,620.72	78,709,521.51
210303	Цэвэр, бохир ус	24,945,636.54	27,712,878.22
2104	Хангамж, бараа материалын зардал	362,329,153.80	269,873,810.98
210401	Бичиг хэрэг	135,495,812.00	60,191,350.00
210402	Тээвэр, шатахуун	66,771,626.50	14,321,175.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	112,690,817.02	131,293,192.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	5,925,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,370,898.28	58,143,093.68
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,074,371.39	206,295,999.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,643,978.00	156,209,280.00
210604	Урсгал засвар	39,430,393.39	50,086,719.60
2107	Томилолт, зочны зардал	9,925,443,370.01	17,024,269,474.81
210701	Гадаад албан томилолт	3,364,636,661.98	3,723,687,385.72
210702	Дотоод албан томилолт	19,002,072.00	12,640,405.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,541,804,636.03	13,287,941,684.09
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,021,985,511.38	2,596,025,889.42

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,513,696,982.38	2,263,591,859.42
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	429,703,390.00	278,680,830.00
210807	Газрын төлбөр	78,585,139.00	53,753,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,676,842,325.25	2,864,655,363.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,676,247,325.25	2,849,740,363.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	595,000.00	14,915,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,410,017,033.00	5,107,262,574.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,261,199,862.38	3,315,434,483.39
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	623,148,667.93
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	623,148,667.93
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	464,184,785.10
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	139,240,798.83
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	19,723,084.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,261,199,862.38	2,692,285,815.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	904,114,360.95	483,098,081.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	110,620,000.00	2,640,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	456,298,081.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	793,494,360.95	24,160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,018,475,578.13	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,388,983,265.62	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	629,492,312.51	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,226,227,231.54	1,308,730,009.61
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,226,227,231.54	1,308,730,009.61
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,285,452,680.86	424,065,532.02
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	6,089,388,110.60	621,920,576.59
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,089,388,110.60	621,920,576.59
2200	Дотоод эх үүсвэрээр	6,089,388,110.60	621,920,576.59
221001	Их засвар	3,940,995,442.00	207,296,636.00
222001	Тоног төхөөрөмж	1,026,858,480.00	335,634,269.59
223001	Бусад хөрөнгө	-	77,871,671.00

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,121,534,188.60	1,118,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(6,089,388,110.60)	(621,920,576.59)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	196,064,570.26	(197,855,044.57)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,086,031.02	202,150,601.28
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	202,150,601.28	4,295,556.71

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,330,370,602.25	895,088,784.63	5,665,351,527.75	9,890,810,914.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,330,370,602.25	895,088,784.63	5,665,351,527.75	9,890,810,914.63
Тайлант үеийн үр дүн	-	-	6,317,397,895.58	6,317,397,895.58
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,330,370,602.25	895,088,784.63	11,982,749,423.33	16,208,208,810.21
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,330,370,602.25	895,088,784.63	11,982,749,423.33	16,208,208,810.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,330,370,602.25	895,088,784.63	11,982,749,423.33	16,208,208,810.21
Тайлант үеийн үр дүн	-	-	(186,468,134.13)	(186,468,134.13)
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,330,370,602.25	895,088,784.63	11,796,281,289.20	16,021,740,676.08

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	46,404,216,300.00	33,797,055,996.19	(12,607,160,303.81)	72.8
12	Татварын бус орлого	46,404,216,300.00	33,797,055,996.19	(12,607,160,303.81)	72.8
120	Нийтлэг татварын бус орлого	100,000,000.00	139,596,407.00	39,596,407.00	139.6
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	100,000,000.00	139,596,407.00	39,596,407.00	139.6
122	Тусламжийн орлого	46,304,216,300.00	33,657,459,589.19	(12,646,756,710.81)	72.7
122005	Төсвөөс санхүүжих	46,304,216,300.00	33,657,459,589.19	(12,646,756,710.81)	72.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,404,216,300.00	33,797,055,996.19	(12,607,160,303.81)	72.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,404,216,300.00	33,797,055,996.19	(12,607,160,303.81)	72.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,677,136,000.00	30,621,672,099.73	(11,055,463,900.27)	73.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,221,450,700.00	7,199,992,933.46	(21,457,766.54)	99.7
210101	Үндсэн цалин	3,879,341,000.00	3,836,242,268.10	(43,098,731.90)	98.9
210102	Нэмэгдэл	2,169,836,400.00	2,161,676,880.47	(8,159,519.53)	99.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	711,142,200.00	772,228,326.38	61,086,126.38	108.6
210104	Урамшуулал	461,131,100.00	429,845,458.51	(31,285,641.49)	93.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	897,567,700.00	897,545,194.43	(22,505.57)	100.0
210201	Тэтгэврийн даатгал	610,393,700.00	610,393,692.56	(7.44)	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	71,892,900.00	71,888,857.97	(4,042.03)	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,887,100.00	35,878,669.00	(8,431.00)	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	35,878,800.00	35,872,875.00	(5,925.00)	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	143,515,200.00	143,511,099.90	(4,100.10)	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	406,296,700.00	259,784,219.97	(146,512,480.03)	63.9
210301	Гэрэл, цахилгаан	143,372,500.00	153,361,820.24	9,989,320.24	107.0
210302	Түлш, халаалт	200,128,700.00	78,709,521.51	(121,419,178.49)	39.3
210303	Цэвэр, бохир ус	62,795,500.00	27,712,878.22	(35,082,621.78)	44.1
2104	Хангамж, бараа материалын зардал	342,322,300.00	274,880,010.98	(67,442,289.02)	80.3
210401	Бичиг хэрэг	70,515,200.00	63,778,550.00	(6,736,650.00)	90.4
210402	Тээвэр, шатахуун	14,321,200.00	14,321,175.00	(25.00)	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	179,588,400.00	131,293,192.30	(48,295,207.70)	73.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,447,600.00	5,925,000.00	(7,522,600.00)	44.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,449,900.00	59,562,093.68	(4,887,806.32)	92.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,231,366,600.00	494,976,286.60	(1,736,390,313.40)	22.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,108,310,900.00	442,277,617.00	(1,666,033,283.00)	21.0
210604	Урсгал засвар	123,055,700.00	52,698,669.60	(70,357,030.40)	42.8
2107	Томилолт, зочны зардал	17,242,053,500.00	17,055,739,474.81	(186,314,025.19)	98.9
210701	Гадаад албан томилолт	3,764,404,900.00	3,755,177,385.72	(9,227,514.28)	99.8
210702	Дотоод албан томилолт	12,640,400.00	12,640,405.00	5.00	100.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	13,465,008,200.00	13,287,921,684.09	(177,086,515.91)	98.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,906,607,000.00	2,212,751,451.54	(6,693,855,548.46)	24.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	8,314,087,700.00	1,866,058,421.14	(6,448,029,278.86)	22.4

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	үйлчилгээний төлбөр хураамж				
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	538,766,100.00	292,939,830.40	(245,826,269.60)	54.4
210807	Газрын төлбөр	53,753,200.00	53,753,200.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,429,471,500.00	2,226,002,527.94	(2,203,468,972.06)	50.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,411,544,500.00	2,211,087,527.94	(2,200,456,972.06)	50.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,927,000.00	14,915,000.00	(3,012,000.00)	83.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,727,080,300.00	3,175,383,896.46	(1,551,696,403.54)	67.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,940,141,600.00	2,692,285,815.46	(1,247,855,784.54)	68.3
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,940,141,600.00	2,692,285,815.46	(1,247,855,784.54)	68.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	786,938,700.00	483,098,081.00	(303,840,619.00)	61.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,640,000.00	2,640,000.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	760,138,700.00	456,298,081.00	(303,840,619.00)	60.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,160,000.00	24,160,000.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	143.00	143.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	10.00	10.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	119.00	119.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	1,280,485,474.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,280,485,474.00
122	Тусламжийн орлого	-	1,280,485,474.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,280,485,474.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,280,485,474.00
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	90,515,624.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	882,990,850.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	306,979,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,121,521,591.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,121,521,591.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,121,521,591.17
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	270,792,539.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	270,792,539.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	850,729,051.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	850,729,051.70
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	158,963,882.83
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(158,963,882.83)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(158,963,882.83)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гадаад харилцааны яам нь Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчин бүрдүүлэх, дэлхийн улс орнуудтай бодит харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхэд үйл ажиллагаа явуулдаг, Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Яам нь гадаад харилцааны талаарх Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээж, Засгийн газрын танхим, сайдыг цаг үеэ олсон мэргэжлийн өндөр түвшний зөвлөгөө, дэмжлэгээр хангах, гадаад харилцааны салбарын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зөв зохистой удирдан зохицуулах, хариуцсан асуудлаар Засгийн газрын зөвлөхийн үүрэг хүлээж, яамд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарыг гадаад бодлогын нэгдсэн зохицуулалтаар хангадаг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус яам нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Дипломат албаны тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Дипломат харилцааны тухай Венийн конвенц, Консулын харилцааны тухай Венийн конвенц, Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хууль;
- Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Засгийн Газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоол /Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам/;
- Сангийн сайдын 2025 оны “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн батлах тухай А/3 дугаар тушаал;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлант хугацаанд яамны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус яам нь 2022 онд шинэчлэн боловсруулсан Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 118,613.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	202,150.6	4,295.6	(197,855.0)
Авлага	96,265.5	52,474.5	(43,791.0)
Урьдчилгаа	744,688.1	1,742.7	(742,945.4)
Бараа материал	471,204.9	757,863.4	286,658.5
Үндсэн хөрөнгө	14,890,949.5	15,470,268.7	579,319.2
Нийт хөрөнгө	16,405,258.6	16,286,644.8	(118,613.8)
Өр төлбөр	197,049.8	264,904.1	67,854.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	16,208,208.8	16,021,740.7	(186,468.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	16,405,258.6	16,286,644.8	(118,613.8)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн их засварын ажлын чанарын баталгааны барьцаа болох 197,855.0 мянган төгрөгийг чөлөөлж ажил гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна;

Урьдчилгаа дансны эхний үлдэгдлээс өмнөх оны 742,945.4 мянган төгрөгийн урсгал засварын ажлыг тайлант онд бүрэн дуусгаж, гэрээг дүгнэн, хүлээн авсаныг тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрч, үлдэгдэл 1,742.7 мянган төгрөг болсон байна.

Бараа материал дансны үлдэгдэл 757,863.4 мянган төгрөгт хүрч 286,658.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд тусгай зориулалтай бараа материалын ангилалд бүртгэсэн албан паспортын бэлдэц, олон улсын хурал зөвлөгөөн зохион байгуулах ажлын хүрээнд хэрэглэх гал тогооны хэрэгслийн худалдан авалтуудтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө Засгийн газрын 2025 оны 90 дүгээр тогтоолоор Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын 1 дүгээр байр (архив)-ын барилгыг Гадаад харилцааны яаманд балансаас баланст шилжүүлэн авсан дүн 957,301.1 мянган төгрөг, Олон улсын хурал зохион байгуулах ажлын хүрээнд худалдан авсан тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын дүн 413,506.0 мянган төгрөг, их засварын ажлын капиталжуулалт 662,783.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын даргын 2025 оны 340 дүгээр тогтоолын дагуу акталсан 1,286,323.0 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн сөрөг үр дүн 186,468.1 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Яамны биет бус хөрөнгийн дансанд 404,809.1 мянган төгрөгийн дипломат, албан паспортын программ, дипломат ажлын шугамаар түр болон удаан хугацаагаар оршин суугчдын бүртгэл, хяналтын программ хангамжууд бүртгэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус яамны 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 51,859,885.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 100,000.0 мянган төгрөг тус тус бүрдүүлэхээр, нийт зарлагыг 51,959,885.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа үйлчилгээний зардлыг 8,655,715.9 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 9,628,103.4 мянган төгрөг, нийт 18,283,819.3 мянган төгрөгөөр урсгал зардлыг бууруулж 33,676,066.4 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулж хүргүүлээгүй байна.

Төсвийн тодотголоор батлагдсан төсвийн бараа үйлчилгээний зардлыг 5,582,106.1 мянган төгрөг нэмэгдүүлж, урсгал шилжүүлгийн зардлыг 453,989.0 мянган төгрөгөөр бууруулж, нийт 5,128,117.1 мянган төгрөгөөр урсгал зардлыг нэмэгдүүлж, 38,804,183.5 мянган төгрөгөөр төсвийг тодотгосон байна.

Төсвийн тодотголоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцаас Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах арга хэмжээний зардал 9,610,832.1 мянган төгрөгийг Гадаад харилцааны яамны төсөвт нэмж тодотгосон байна. Энэхүү шилжиж ирсэн төсөв нь Соёлын яамны гадаадын 3 байгууллагатай байгуулсан өндөр үнийн дүнтэй, цуцлах тохиолдолд алданги, хүү тооцох хатуу нөхцөлтэй, арбитр болон гадаад улсын шүүхээр маргаан хянан шийдвэрлэх зохицуулалт бүхий гэрээнүүдийн төлбөр байна.

Тайлант онд төсөвт дараах зохицуулалтуудыг хийсэн байна. Үүнд:

- Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 03/3363 дугаар албан бичгээр Улс орноо сурталчлах зардлыг 2,638,000.0 мянган төгрөгөөр бууруулж, олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах зардлыг 2,000,000.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 498,000.0 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 30,000.0 мянган төгрөгөөр, шуудан холбооны зардлыг 75,000.0 мянган төгрөгөөр, эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардлыг 35,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн;
- Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 03/3734 дүгээр албан бичгээр ДТГ-ын урсгал төсвийг 4,000,000.0 мянган төгрөгөөр бууруулж, яамны байр ашиглалтын зардлыг 2,000,000.0 мянган төгрөгөөр, багаж хэрэгслийн зардлыг 2,000,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн;
- Гадаад харилцааны сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/4937 дугаар албан бичгээр ДТГ-ын урсгал зардлыг 6,606,500.0 мянган төгрөгөөр бууруулж, Гадаад харилцааны яамны гадаад албан томилолт зардлыг 320,000.0 мянган төгрөгөөр, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 3,300,000.0 мянган төгрөгөөр, Улс орноо сурталчлах зардлыг 2,986,500.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн;

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 25- 02/6095 тоот албан бичгээр Юнескогийн ажлын албаны бусад нийтлэг, ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 19,967,200.0 нэмэгдүүлж, яамны гэрэл, цахилгааны зардлыг 19,967,200.0 мянган төгрөгөөр бууруулсан зохицуулалтуудыг хийсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 46,304,216.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 100,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 33,657,459.6 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 139,596.4 мянган төгрөг, нийт 33,797,056.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, бараа, ажил, үйлчилгээний зардалд 30,621,672.1 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 3,175,383.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 33,797,056.0 мянган төгрөг буюу 72.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 2,406,977.6 мянган төгрөг, улс орноо гадаад сурталчлах зардлыг 6,393,436.3 мянган төгрөг, байр ашиглалтын үйлчилгээний зардлыг 2,159,766.1 мянган төгрөг, Олон улсын байгууллагын гишүүнчлэл хураамжийн зардлыг 1,247,855.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Улс орноо гадаад сурталчлах арга хэмжээний гүйцэтгэл 12.1 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Засгийн газрын шийдвэр гараагүй тул олон улсын байгууллагуудтай байгуулсан гэрээний төлбөрүүдийг шилжүүлээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70305	Гадаад харилцааны бодлого, удирдлага	46,404,216.3	33,797,056.0	12,607,160.3	72.8%
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	28,951,503.8	26,544,526.2	2,406,977.6	91.7%
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	74,500.0	74,500.0	-	100.0%
80218	Улс орноо гадаадад сурталчлах	7,277,598.9	884,162.6	6,393,436.3	12.1%
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	2,753,114.2	593,348.1	2,159,766.1	21.6%
80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэл хураамж	3,940,141.6	2,692,285.8	1,247,855.8	68.3%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	786,938.7	483,098.1	303,840.6	61.4%
81520	Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	1,523,543.4	1,522,830.4	713.0	99.9%
81549	Ахмадын сан	36,185.5	26,207.6	9,977.9	72.4%
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	961,988.8	907,395.9	54,592.9	94.3%
82905	Засгийн газар хоорондын комисс	98,701.4	68,701.4	30,000.0	69.6%

Тайлант онд цалингийн зардлыг 7,456,429.9 мянган төгрөгөөр баталсан ба төсвийн тодотголоор 434,979.2 мянган төгрөгөөр бууруулж 7,021,450.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/346 дугаар тушаалаар яамны бүтэц орон тоог 14 орон тоогоор бууруулж, 143 орон тоогоор шинэчлэн баталсан байна. Гүйцэтгэлээр удирдах 10, гүйцэтгэх 119, үйлчлэх 14 албан хаагч ажиллаж байна.

Төрийн нарийн бичгийн 2025 оны А/399 дүгээр тушаалаар албан хаагчдад ажлын нэг өдөрт хоолны зардалд 32.0 мянган төгрөг, унааны зардалд 3.0 мянган төгрөгийг олгохоор баталсан байна. Тайлант онд гүйцэтгэлээр хоол унааны хөнгөлөлтөд 772,228.3 мянган төгрөгийг зарцуулсан.

Гадаад томилолтын зардалд 265 удаагийн томилолтыг 3,764,404.9 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 3,755,177.4 мянган төгрөг, гадаад зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 13,465,008.2 мянган төгрөгийн төсөв баталж, 13,287,921.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах зардлыг 1,523,543.4 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 1,522,830.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант оны 8 дугаар сард Зүүн Ази, Латин Америкийн хамтын ажиллагааны гишүүн орнууд (ФЕАЛАК)-ын Гадаад хэргийн сайд нарын 10 дугаар уулзалт, олон улсын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар БНХАУ-ын Гадаад хэргийн сайдын албан ёсны айлчлалын хүрээнд 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр яамны үйл ажиллагаанд үзүүлсэн 950,000.0 мянган төгрөгийн дэмжлэгийн үлдэгдэл 90,515.6 мянган төгрөг, Засгийн газрын нөөц сангаас Засгийн газрын 2025 оны 164 дүгээр тогтоолын дагуу 353,000.0 мянган төгрөг, Засгийн газрын 2025 оны 49 дүгээр тогтоолын дагуу 356,980.0 мянган төгрөгийн гадаад улсад үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн шилжүүлэг, Засгийн газрын 2025 оны 86 дугаар тогтоолын дагуу “Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенцод оролцогч талуудын бага хурлын 11 дүгээр чуулган” зохион байгуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах 172,810.9 мянган төгрөгийн орлого, Засгийн газрын 2025 оны 49 дүгээр тогтоолын дагуу хүмүүнлэгийн тусламжийн гадаад шилжүүлгийн банкны шимтгэл 200.0 мянган төгрөг, Нийслэлийн ЗДТГ-аас шилжүүлсэн Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны 2025 оны 05 дугаар тогтоолоор “Миний монгол наадам” арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд 200,000.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны нэмэлт 106,979.0 мянган төгрөгийн орлого, нийт 1,280,485.5 мянган төгрөгийн орлого бүрдсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос Засгийн газрын тогтоолуудын дагуу хүмүүнлэгийн тусламж дэмжлэгт 710,180.0 мянган төгрөг, “Миний монгол наадам” арга хэмжээг зохион байгуулах ажилд 200,000.0 мянган төгрөг, “Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенцод оролцогч талуудын бага хурлын 11 дүгээр чуулган” зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 140,549.1 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 139,240.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, үүнээс 19,723.1 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Гадаад харилцааны яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 780,460.8 мянган төгрөгийн 28 бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөж баталсан байна.

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Гүйцэтгэлээр 461,970.0 мянган төгрөгийн 25 бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авалтаар, 7,460.0 мянган төгрөгийн 1 ажил, үйлчилгээг харьцуулалтын ерөнхий гэрээгээр, 148,900.0 мянган төгрөгийн ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна. Нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулахаар төлөвлөсөн яамны төв архивын барилгын агаар сэлгэлт, хөргөлтийн системүүдийн засварын ажлыг 120,000.0 мянган төгрөгөөр төсөвлөсөн боловч төсөвт өртөг хүрэлцээгүй шалтгаанаар тус арга хэмжээ хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн газар, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн яамны үйл ажиллагааг сайжруулах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор П.Батцэцэг, Аудитор С.Алтанхуяг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/322 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 28,492,313.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 284,923.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд албан хэрэг хөтлөлтийг цахимаар явуулах, албан томилолтоор онгоцоор явахад энгийн ангиллаар зорчих, ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авалтыг гүйцэтгэх зэргээр хуульд заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 884,925.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилт, дотоод хяналт, хариуцлагыг сайжруулахтай холбоотой 3 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудаст мэдээлэх цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт мэдээлэх 309 мэдээллээс 1,843,041.1 мянган төгрөгийн 5 орлогын гүйлгээ, 3,515,413.4 мянган төгрөгийн 36 зарлагын гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 4.1.4-т "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд тухай бүр мэдээлж байх зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Гадаад харилцааны яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 884,925.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авсан, мөн нэг төрлийн бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулах аргаар худалдан авахаар төлөвлөсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5-т "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авах бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг мөрдөөгүй, төсөвт өртгийг олон хувааж шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/286, А/298 дугаар "Зардал гаргах тухай" тушаалын эрх зүйн үндэслэлийг буруу тусгасан байна. /Тухайлбал: Тушаалын үндэслэлд заасан Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль нь 5 бүлэг, 26 зүйлтэй хууль байхад тус хуульд байхгүй 16.5.5, 47.1.1-ийг үндэслэн гэж буруу тусгасан байна/

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Захиргааны үйл ажиллагаанд дараах тусгай зарчмыг баримтална", 4.2.1-д "хуульд үндэслэх", 4.2.5-д "зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал, шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэлийг бодитой, зөв үндэслэл бүхий зүйл заалт сонгож хэрэглэх, тушаал шийдвэрийн үндэслэлд хяналт тавих дотоод хяналтыг сайжруулах талаар зөвлөмж өгөв.

Илрүүлэлт 3: Тус яамны бүтэц орон тоог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/346 дугаар тушаалаар баталсан боловч албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлаагүй, тухайлбал Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан албан хаагч Франц хэлний орчуулагч мэргэжилтэй, АЗ гэрчилгээгүй албан тушаалтан байгаа нь худалдан авах үйл ажиллагааны зохион байгуулалтын чанарыг алдагдуулж, аудит хийхэд хүндрэл үүсгэж байна.

Энэ нь Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3-т "Албан тушаалын тодорхойлолт нь төрийн албан хаагч тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг хариуцах үндэслэл болно", 3 дугаар зүйлийн 3.8-д "Албан тушаалын зорилтын хүрээнд хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлохдоо "Албан тушаалын тодорхойлолтын маяг"-ын дагуу албан тушаалтны хариуцлага, оролцооны хэлбэрийг тодорхой дурдана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлах, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан албан хаагчийг тухайн албан тушаалд томилон ажиллуулдаг байх, энэхүү асуудалд дотоод хяналтыг сайжруулах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, мөн тушаалын эрх зүйн үндэслэлийг буруу сонгосон, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлаагүй зэрэг нь Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны зөвлөлийн тогтоолын холбогдох заалтуудтай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Гадаад харилцааны яамны 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийж, 19,556,269.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснийг асуудлын бүртгэлээр танилцуулсан.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 38,556.2 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага, 31,886.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 7 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд 75.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	38,556.2	1	38,556.2	100.0
Зөвлөмж	7	31,886.0	5	31,886.0	71.4

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нийт дүн	8	67,686.6	6	67,686.6	75.0
----------	---	----------	---	----------	------

Тус яамны нэр дээр бүртгэлтэй зуслангийн газруудыг үнэлж, данс бүртгэлд тусгах болон авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх талаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

- Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны 2025 оны 5 дугаар тогтоолоор "Миний монгол наадам" арга хэмжээг зохион байгуулахаар Нийслэлийн ЗДТГ-аас 200,000.0 мянган төгрөгийг тус яамны нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан. Улсын төсөв болон орон нутгийн төсвийг хольж зарцуулсан асуудлыг анхаарах;
- Урсгал болон нэмэлт төсвөөс Олон арга хэмжээ зохион байгуулахад зориулж нийт 1,076,289.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Урсгал төсвөөс хөрөнгө бэлтгэж байгаа асуудлыг анхаарах;
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гадаад хэргийн сайдын албан ёсны айлчлалын хүрээнд 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр яамны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж нэмэлт санхүүжилтийн дансанд 950,000.0 мянган төгрөг шилжүүлсэн байна. Тус хөрөнгийн үлдэгдлийг 2022 он, 2023 он, 2024 онуудад жил бүр Сангийн яамны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлж, авлага үүсгэн тооцоо нийлж буцаан авч зарцуулсан байна. Тайлант онд тус хөрөнгийн үлдэгдлээс 70,792.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Он дамжуулан авлага үүсгэж, ямар нэгэн тооцоо судалгаагүй, хөрөнгө бэлтгэж байгаа асуудлыг анхаарах;
- Гадаад харилцааны яамны зочин төлөөлөгч хүлээн авах зардлын гүйцэтгэл, хэрэгжүүлж буй дотоод хяналтад нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,308,730.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа:

Улсын тэмдэгтийн хураамжийн 1,308,730.0 мянган төгрөгийн орлогыг Төрийн банкны дансанд тухай бүр төвлөрүүлж /тэг үлдэгдэлтэй арилжааны банкны данс/, Сүхбаатар дүүргийн төрийн сангийн Улсын тэмдэгтийн хураамжийн татагддаг боловч, урсгал зардлын дансанд бөөн дүнгээр орлогоор бүртгэж, "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга, үнэн зөв, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын орлого болох улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг урсгал зардлын дансаар дамжуулан санхүүгийн тайланд давхар тайлагнахгүй байх зөвлөмж өгөв. .

Аудитаар нийт 442,381.5 мянган төгрөгийн 16 зөрчил² илэрснээс 20,909.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 5 албан шаардлага хүргүүлж, 421,472.3 мянган төгрөгийн 9 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 1,751,111.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Илрүүлэлт: Гадаад харилцааны яамны техник хяналтын дансанд Хөмотэ ХХК-ийн 2018 онд гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын ажлын техник хяналтын 4,237.2 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна..

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Техник хяналтын дансны зарцуулаагүй үлдэгдэлийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Илрүүлэлт: Тайлант онд томилолтоор явсан албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан тооцож 16,672.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим"-ийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам" 2.1-д "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно", 2.2-т "албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ" 2.2.1-д "унааны зардал", 2.2.2-т "байрны зардал", 2.2.3-т "хоолны зардал" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдад илүү тооцож олгосон хоол, унааны зардал буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт: Хөрөнгийн тооллогыг хагас жилээр болон эд хөрөнгө хариуцагч, эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хийж хэвшээгүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг батлагдсан маягтын дагуу хөтөлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.2-т "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг батлагдсан маягтын дагуу хөтөлж, баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Илрүүлэлт: Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа Ахплорер ХХК-ийн ExplorerX санхүүгийн программ хангамж нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад бүртгэлгүй, программаас гарч буй мэдээ, тайлангууд нь зөрүүтэй байгаагаас аудитын тулган баталгаажуулалт хийхэд хүндрэлтэй, байгууллагын нягтлан бодох бүртгэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх", Сангийн сайдын 2022 оны 9 сарын 30-ний өдрийн 197 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Аж ахуй нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын 1.2-т "Тооцооны аргачлал нь олон улсын стандартад заагдсан бүх аргыг хэрэглэх боломжтой байх", 1.10-т "Санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй, мэдээллийн эх үүсвэр иж бүрнээр /анхан шатны баримтын мэдээлэл, дансанд бичилт хийсэн мэдээлэл/ тодорхой харуулдаг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамж ашиглаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Илрүүлэлт: Гэрэгэ систем ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 2 жилийн хугацаатай байгуулсан орлого төвлөрүүлэхтэй холбоотой гэрээг шинэчлэн байгуулаагүй, улирал, жилээр тооцоо нийлж акт үйлдээгүй, гэрээний хавсралтад дансны мэдээллийг буруу тусгаснаас үндсэн үйл ажиллагааны орлого болон нэмэлт орлого олон дансанд төвлөрч санхүүгийн тайланг бэлтгэх болон аудитын тулган баталгаажуулах горим сорил гүйцэтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д *"Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно"*, 7.3-т *"Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрэгэ систем ХХК-тэй байгуулсан гэрээгээ шинэчлээгүй, орлого төвлөрүүлэх дансны мэдээллийг гэрээнд буруу тусгасан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. Илрүүлэлт: Өмнөх аудитаар яамны нэр дээр бүртгэлтэй зуслангийн газруудыг үнэлж, данс бүртгэлд тусгах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу авто тээврийн хэрэгсэлд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх талаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална"*, 5.1.4-т *"үнэн зөв байх"*, 14 дугаар зүйлийн 14.4-т *"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ"*, 14.4.2-т *"бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"*, 20 дугаар зүйлийн 20.2.3-т *"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д *"Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5. Илрүүлэлт: Гадаад харилцааны яам нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг иж бүрэн тодруулга, толилуулгын хамт бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д *"Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна"*, 8.1.5-д *"санхүүгийн тайлангийн тодруулга"*, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т *"Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн"*

хэсэгтэй байна”, 54.5.4-т “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/”, Сангийн сайдын 2024 оны А/3 тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 8 дугаар бүлгийн “Санхүүгийн тайлангийн тодруулга”-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг иж бүрэн тодруулга, толилуулгын хамт бэлтгэж ирүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланг тусдаа бэлтгэж байхад хөрөнгө оруулалттай холбоотой барьцаа, техник хяналтын зардлын дансдын үлдэгдлийг яамны санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө оруулалтын барьцаа, техник хяналт данстуудыг төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэн тайлагнах.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас 43,839.2 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл хангаагүй зарлагын гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Монгол Улсын Засгийн газрын 444 тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.12.1-д “Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг өөрийн нэмэлт төсвийн дансаар дамжуулан хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулна”, 2.12.2.2-т “нэмэлт төсвийг зарцуулах тухай төсвийн захирагчийн шийдвэр болон бусад холбогдох шийдвэр”, 3.4.7-д “Төсвийн байгууллага бүртгэлийн данснаас зарлагын гүйлгээ хийхдээ энэ журмын 2 дугаар хавсралтад заасан “маягт ТТ-2А”-ийн дагуу төлбөрийн хүсэлтийг 2 хувь үйлдэн гарын үсэг зурж, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулан, хяналтын хэсэгт тусгасан үндэслэх баримтын эх хувийн хамт харьяа төрийн санд ирүүлэх, эсхүл цахимаар баталгаажуулан илгээнэ. Үндэслэх баримтын мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага хариуцна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил, гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэхгүй байх.

3. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материал дансны үлдэгдэлд 2018 онд орлогод авсан 15,288.0 мянган төгрөгийн ашиглагдах боломжгүй болсон 1960 ширхэг энгийн дипломат паспортын бэлдэц бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д *"Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно"*, 15.1.6-д *"нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглагдах боломжгүй болсон дипломат паспортын бэлдэцийг өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулан, устгалтын акт үйлдэн данс бүртгэлээс хасах, цаашид их хэмжээгээр дипломат паспортын бэлдэцийг хэвлүүлж, нөөц үүсгэхгүй байх.

4. Үндсэн хөрөнгө актлахтай холбоотой асуудал

Илрүүлэлт: ТӨБЗГ-ын 2025 оны 340 дүгээр тогтоолоор 391 нэрийн 1,299,085.4 мянган төгрөгийн хөрөнгийг ӨХБЗ-ийн хяналт дор акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах ажлыг даалгасан шийдвэр гарсан боловч акталсан тухай шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, устгалын комиссын акт үйлдээгүй, дахин ашиглах, сэлбэг хэрэглэлээр ашиглах боломжтой эсэхийг судлан баримтжуулаагүй, хэт өндөр үнэлгээтэй тавилга эд хогшил акталсан байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тогтоол *"Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"*-ын 8 дугаар зүйлийн 8.1-д *"Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлнэ"*, 8.3-т *"Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах шийдвэрийн хэрэгжилтийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох данс бүртгэлд тусгана"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, баримтжуулж байх.

5. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд үндсэн хөрөнгийн шинж чанарыг агуулаагүй бэлтгэлийн хувцас, сагсан бөмбөгийн өмсгөл, айлчлалын бэлэг дурсгал зэрэг 11,393.0 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэж, элэгдэл байгуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх"*, 20 дугаар зүйлийн 20.2.4-т *"нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"*, 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д *"Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын*

хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн шинж чанар агуулаагүй бараа материалыг ТӨБЗГ-т хандан шийдвэр гаргуулан үндсэн хөрөнгийн данснаас хасан бараа материалын дансанд бүртгэх.

6. Гадаад томилолттой холбоотой асуудал

Илрүүлэлт: Гадаад томилолтын зардлаас түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд тайлант оны 159,159.2 мянган төгрөгийн гадаад томилолтын зардлын тооцоог хийхдээ томилолтын илтгэх хуудас, тайланг бэлтгүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйл 20.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Томилолтоор ажилласан албан хаагчдаас томилолтын илтгэх хуудас, тайланг авч томилолтын тооцоог бодож хэвших.

7. Зардлын эдийн засгийн ангилалтай асуудал

Илрүүлэлт: Тайланд хугацаанд зардлын эдийн засгийн ангилал зөрчиж нийт 191,210.2 мянган төгрөгийн дараах ажил гүйлгээг гүйлгэн зарцуулсан байна. Үүнд:

1. Бараа үйлчилгээний бусад зардлаас гадаад томилолтын зардалд 121,842.7 мянган төгрөг, ахмадын хорооны гишүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний зардалд 24,100.0 мянган төгрөг;
2. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас авто машины татвар, даатгалын хураамжид 13,777.5 мянган төгрөг тус тус зарцуулсан;
3. Гадаад томилолтын зардлаас 31,490.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 42.3.1-т "төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх", "Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж ажил гүйлгээ гаргахгүй байх, төсвийг төлөвлөхдөө бодитой төлөвлөж зарцуулах.

8. Түрээстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Гадаад харилцааны яамны 10 дугаар давхрын зоогийн газар /320м.кв/, 1 дүгээр давхрын зоогийн газар /162м.кв/, кофе шоп /80м.кв/, 148,548.0 мянган төгрөгийн

тавилга, тоног төхөөрөмж, 110,165.3 мянган төгрөгийн хангамжийн материалыг тус тус үнэ төлбөргүйгээр ДБҮЭГ-т ашиглуулж байна.

Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 2.16-д *"Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэхдээ түрээсийн төлбөрийн хэмжээг энэ журмын 11-д заасан жишиг үнийг баримтлан, зах зээлийн тухайн үеийн үнэ болон бусад холбогдох үзүүлэлтүүдийг харгалзан тогтоож, гэрээнд тусгана"*, 2.17-д *"Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төвлөрүүлж улсын төвлөрсөн төсөвт оруулна. Улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хувь, хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтооно"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй ашиглуулж буй өрөө болон хөрөнгийг түрээслүүлэх гэрээ байгуулж, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх.

9. Төсвийн төлөвлөлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийг бодитой төлөвлөөгүй, сар бүрийн хуваарийг оновчтой хуваарилдаггүйгээс ДБҮЭГ-ээс авч буй үйлчилгээний хөлс харилцан адилгүй, хэзээ хэдэн төгрөгийн зардал гарах нь тодорхойгүй, тухай бүр засвар, үйлчилгээний хөлс гэх мэт гүйлгээ хийж байгаа нь нягтлан бодогчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтал"*, 5.1.4-т *"үнэн зөв байх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөх, ДБҮЭГ-ээс авч буй ажил, үйлчилгээг төлөвлөж, ерөнхий гэрээ байгуулан зардалд хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн		
							Тоо	Дүн	Тоо	Дүн				
Улсын Тэмдэгтийн хураамжийн 1,308,730.0 мянган төгрөгийн орлогыг Төрийн банкны дансанд тухай бүр төвлөрүүлж /тэг үлдэгдэлтэй арилжааны банкны данс/, Сүхбаатар дүүргийн төрийн сангийн Улсын тэмдэгтийн хураамжийн дансанд татагддаг боловч, урсгал зардлын дансанд бөөн дүнгээр орлогоор бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан байна.	1	1,308,730.0			1	1,308,730.0					1	1,308,730.0		
Дүн	1	1,308,730.0			1	1,308,730.0					1	1,308,730.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Техник хяналтын дансанд Хөмөтэ ХХК-ийн 2018 онд гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын ажлын техник хяналтын 4,237.2 мянган төгрөгийн үлдэгдэл байршиж байна.	1	4,237.2	1	4,237.2								
Цалингийн зардлаас түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд тайлант онд албан хаагчдын цалин тооцоходоо томилолтоор явсан албан хаагчдад хоол, унааны мөнгийг давхардуулан тооцож 16,672.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	16,672.0	1	16,672.0								
Хөрөнгийн тооллогыг хагас жилээр болон эд хөрөнгө хариуцагч, эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хийж хэвшээгүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг батлагдсан маягтын дагуу чанартай тоолж баталгаажуулаагүй байна.	1	-			1	-						
Гадаад харилцааны яам нь Ахплорер ХХК-ийн -ны АхплорегХ санхүүгийн программыг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тус программ хангамж нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад бүртгэлгүй, программаас гарч буй мэдээ, тайлангууд хоорондоо зөрүүтэйн улмаас аудитын тулган баталгаажуулалт хийхэд хүндрэлтэй,	1	-			1	-						

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

байгууллагын нягтлан бодох бүртгэл хэвийн бус явагдах эрсдэл үүсгэж байна.												
Гэрэгэ систем ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 2 жилийн хугацаатай байгуулсан орлого төвлөрүүлэхтэй холбоотой гэрээг шинэчлэн байгуулаагүй, улирал, жилээр тооцоо нийлж акт үйлдээгүй, гэрээний хавсралтад өөрийн данстуудыг хольж гэрээ байгуулснаас урсгал данс, нэмэлт данстуудын орлого холилдож санхүүгийн тайлан гаргах болон аудитын тулган баталгаажуулах горим сорил гүйцэтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байна.	1	-			1	-						
Өмнөх аудитаар яамны нэр дээр бүртгэлтэй зуслангийн газруудыг үнэлж, бүртгэлд тусгах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу авто тээврийн хэрэгсэлд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх талаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-			1	-						
Гадаад харилцааны яам нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг иж бүрэн тодруулга, толилуулгын хамт бэлтгэж ирүүлээгүй байна.	1	-			1	-						
Тус яамны Хөрөнгө оруулалтын дансанд ТЕЗ-ийн ерөнхий нягтлан 2-р гарын үсэг зурж баталгаажуулж байгаа боловч, Хөрөнгө оруулалтын барьцаа, техник хяналт зэрэг данстуудын үлдэгдлийг ТШЗ-ийн тайланд тусган тайлагнасан байна.	1	-					1	-				
Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас 43,839.2 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл хангаагүй гүйлгээ хийсэн байна.	1	43,839.2					1	43,839.2				
Бараа материал дансанд 2018 онд орлогод авсан 15,288.0 мянган төгрөгийн	1	15,288.0					1	15,288.0				

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ашигладаггүй 1960 ширхэг энгийн дипломат паспортын бэлдэц байна.												
ТӨБЗГ-ын 2025 оны 340 дүгээр тогтоолоор 391 нэрийн 1,299,085.4 мянган төгрөгийн хөрөнгийг ӨХБЗ-ийн хяналт дор акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах ажлыг даалгасан шийдвэр гарсан боловч акталсан тухай шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, устгалын комиссын акт үйлдээгүй, дахин ашиглах, сэлбэг хэрэгслээр ашиглах боломжтой эсэхийг судлан баримтжуулаагүй, хэт өндөр үнэлгээтэй тавилга эд хогшил акталсан зэрэг байна.	1	-					1	-				
Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд үндсэн хөрөнгийн шинж чанар агуулаагүй бэлтгэлийн хувцас, сагсан бөмбөгийн өмсгөл, айлчлалын бэлэг дурсгал зэрэг 11,393.0 мянган төгрөгийн зүйлсийг бүртгэж 582.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.	1	11,975.6					1	11,975.6				
Гадаад томилолтын зардлаас түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд тайлант онд 159,159.2 мянган төгрөгийн томилолт илтгэх хуудас, томилолтын тайлангүй байна.	1	159,159.2					1	159,159.2				
Тайланд хугацаанд зардлын эдийн засгийн ангилал зөрчиж дараах ажил гүйлгээг гаргасан байна. 1. Бараа үйлчилгээний бусад зардлаас гадаад томилолтын зардал 121,842.7 мянган төгрөг, ахмадын хорооны гишүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний зардалд 24,100.0 мянган төгрөг, 2. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас авто машины татвар, даатгалын хураамжид 13,777.5 мянган төгрөг тус тус зарцуулсан,	1	191,210.2					1	191,210.2				

Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3. Урсгал зардлын гадаад томилолтын зардал /210701/ эдийн засгийн ангиллаас 31,490.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.												
Гадаад харилцааны яамны 10 давхрын зоогийн газар /320м.кв/, 1 дүгээр давхрын зоогийн газар /162м.кв/, кофе шоп /80м.кв/, 148,548.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, 110,165.3 мянган төгрөгийн бараа материалыг тус тус үнэ төлбөргүйгээр ДБҮЭГ-т ашиглуулж байна.	1	-					1	-				
Төсвийг бодитой төлөвлөөгүй, сарчилсан хуваарийг оновчтой хийдэггүйгээс ДБҮЭГ-ээс авч буй үйлчилгээний хөлс харилцан адилгүй, хэзээ хэдэн төгрөгийн зардал гарах нь тодорхойгүйн улмаас, сар бүрийн эцэст гүйцэтгэлээр тухай бүр засвар, үйлчилгээний хөлс гэх мэт гүйлгээ хийж байгаа нь нягтлан бодогчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.	1	-					1	-				
Дүн	16	442,381.5	2	20,909.2	5	-	9	421,472.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Шилэн дансны цахим хуудаст мэдээлэх цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт мэдээлэх 309 мэдээллээс орлогын 1,843,041.1 мянган төгрөгийн 5 мэдээлэл, зарлагын 3,515,413.4 мянган төгрөгийн 36 мэдээллийг байршуулаагүй байна.	1	-			1	-
Дүн		1	-			1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
1	Гадаад харилцааны яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 884,925.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авсан, мөн нэг төрлийн бараа, ажил үйлчилгээг гэрээ шууд байгуулах аргыг ашиглан олон хувааж худалдан авахаар төлөвлөсөн.	1	884,925.0	1	884,925.0		
2	Тус яамны бүтэц орон тоог ТНБД-ын 2025 оны А/346 дугаар тушаалаар баталсан боловч албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлаагүй, тухайлбал Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан албан хаагч Франц хэлний орчуулагч мэргэжилтэй, АЗ гэрчилгээгүй хүн ажиллаж байгаа нь Худалдан авах үйл ажиллагааны зохион байгуулалтын чанарыг алдагдуулж, аудит хийхэд хүндрэл үүсгэж байна.	1	-			1	-
3	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/286, А/298 дугаар "Зардал гаргах тухай" тушаалын эрх зүйн үндэслэлийг буруу тусгасан байна. /Тухайлбал: Тушаалын үндэслэлд заасан Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль нь 5 бүлэг, 26 зүйлтэй хууль байхад тус хуульд байхгүй 16.5.5, 47.1.1-ийг үндэслэн гэж буруу тусгасан байна/	1	-			1	-
Дүн		3	884,925.0	1	884,925.0	2	-
Нийт дүн		4	884,925.0	1	884,925.0	3	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 13/АД171076

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад харилцааны яамны техник хяналтын дансанд Хөмөтэ ХХК-ийн 2018 онд гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын ажлын техник хяналтын 4,237,191.00 /Дөрвөн сая хоёр зуун гучин долоон мянга нэг зуун ерэн нэгэн/ төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-т “Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төсөвт буцаан төвлөрүүлээгүй 4,237,200.00 /Дөрвөн сая хоёр зуун гучин долоон мянга нэг зуун ерэн нэг/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг), Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Отгонцэцэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
С.АЛТАНХУЯГ

1526200033



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 14/АДИ71076

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад харилцааны яамны цалингийн зардлаас түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд тайлант онд томилолтоор явсан албан хаагчдад хоол, унааны мөнгийг давхардуулан тооцож 16,672,000.00 /Арван зургаан сая зургаан зуун далан хоёр мянга/ төгрөгийг олгосон байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим"-ийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам" 2.1-д "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно", 2.2-т "албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ" 2.2.1-д "унааны зардал", 2.2.2-т "байрны зардал", 2.2.3-т "хоолны зардал" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 "...бусад нөхцөл байдал үүссэн"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан хаагчдад илүү олгосон хоол, унааны зардал 16,672,000.00 /Арван зургаан сая зургаан зуун далан хоёр мянган/ төгрөгийг нягтлан бодогч С.Батхишигээр төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Отгонцэцэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230

Z:\Akt\2026\0225 SAG-8.Docx

1526200035



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 95/А0171076

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад харилцааны яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 884,925,000.00 / найман зуун наян дөрвөн сая есөн зуун хорин таван мянган/ төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авсан, мөн нэг төрлийн бараа, ажил үйлчилгээг гэрээ шууд байгуулах аргыг ашиглан олон хувааж худалдан авахаар төлөвлөсөн.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5-т "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авах бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг мөрдөөгүй, төсөвт өртгийг олон хувааж шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг), Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Отгонцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР


7096109
ATA16687
9025681411

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-10.Docx

1526180229



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 96/АД171076

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгийн тооллогыг хагас жилээр болон эд хөрөнгө хариуцагч, эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хийж хэвшээгүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг батлагдсан маягтын дагуу чанартай тоолж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.2-т "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийж, баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг), Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Отгонцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
С.АЛТАНХУЯГ

9006109
ATA10007
9025021411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 97/А0171076

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад харилцааны яам нь Аксплорер ХХК-ийн ExplorerX санхүүгийн программыг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тус программ хангамж нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад бүртгэлгүй байна. Тус яамны санхүүгийн программаас гарч буй мэдээ, тайлангууд хоорондоо зөрүүтэйн улмаас аудитаар тулган баталгаажуулалт хийхэд хүндрэлтэй, байгууллагын нягтлан бодох бүртгэл хэвийн бус явагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх", Сангийн сайдын 2022 оны 9 сарын 30-ний өдрийн 197 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Аж ахуй нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын 1.2-т "Тооцооны аргачлал нь олон улсын стандартад заагдсан бүх аргыг хэрэглэх боломжтой байх", 1.10-т "Санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй, мэдээллийн эх үүсвэр иж бүрнээр /анхан шатны баримтын мэдээлэл, дансанд бичилт хийсэн мэдээлэл/ тодорхой харуулдаг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамж ашиглаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг), Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Отгонцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
С.АЛТАНХУЯГ

9025107
ATA15087
9025081411

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-10.Docx

1526180233



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 98/А0171076

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрэгэ систем ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 2 жилийн хугацаатай байгуулсан орлого төвлөрүүлэхтэй холбоотой гэрээг шинэчлэн байгуулаагүй, улирал, жилээр тооцоо нийлж акт үйлдээгүй, гэрээний хавсралтад өөрийн данстуудыг хольж гэрээ байгуулснаас урсгал данс, нэмэлт данстуудын орлого холилдож санхүүгийн тайлан гаргах болон аудитын тулган баталгаажуулах горим сорил гүйцэтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", 7.3-т "Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Гэрэгэ систем ХХК-тэй байгуулсан гэрээгээ шинэчлээгүй, орлого төвлөрүүлэх данстыг хольж гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг), Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Отгонцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
С.АЛТАНХУЯГ

9006109
ATA10097
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 99/АД/171076

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТШЗ.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар яамны нэр дээр бүртгэлтэй зуслангийн газруудыг үнэлж, бүртгэлд тусгах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу авто тээврийн хэрэгсэлд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх талаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4 үнэн зөв байх", 14 дугаар зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг), Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Отгонцэцэг) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
С.АЛТАНХУЯГ

9006109
АТА16087
9025301411

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-10.Docx

1526180237



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 100/А0171076

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаад харилцааны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад харилцааны яам нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг иж бүрэн тодруулга, толилуулгын хамт бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:", 8.1.5-д "санхүүгийн тайлангийн тодруулга", Төсвийн тухай хуулийн 54.5-т Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.4-д хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/, Сангийн сайдын 2024 оны А/3 тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8 дугаар бүлгийн "Санхүүгийн тайлангийн тодруулга"-тай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1.нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг иж бүрэн тодруулга, толилуулгын хамт бэлтгэж ирүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг), Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Отгонцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
С.АЛТАНХУЯГ